

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Засаг даргын тамгын газар нь байгууллагын дотоод хурлыг 7 хоног бүрийн пүрэв гаригт тогтмол хийж цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллаж байна. Энэ сарын 4-ны өдөр сумын төвийн эзэнгүй нохойнуудыг устгах ажлыг зохион байгуулж 63 нохой устгаж 1,260,000 төгрөгний зардал гарсан байна. мөн 5 дугаар сарын 5-ны өдөр сумын хэмжээнд нийтийн цэвэрлэгээний ажил зохион байгуулж нийтийн эзэмшлийн газар болон эзэнгүй гудамж талбайг, Дархан хаан уулын ойр орчимыг цэвэрлэж 15тн хогийг нийтийн хогийн цэгт асгаж устгасан. 5 дугаар сарын 6,7-ны өдрүүдэд Жавхлант шарга 2023 уралдаан зохион байгуулагдаж 7 насны 285 морь уралдаж 155 уралдаанч хүүхэд уралдааны замд гарсан байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ажлын хэсэг, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ажлын хэсэг, сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтанаас бүрдсэн хүүхэд хамгааллын баг уралдаанч хүүхдийн бүртгэл, хамгаалалтын хувцасны бүрэн байдалд хяналт хийж уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллаа. Уралдааны үеэр мориноос унаж бэртсэн хүүхэд байхгүй. Мөн уралдааны үеэр Сумын тамгын газар хүндэтгэлийн өргөөгөө наадмын талбайд барьж ирсэн зочидод хүндэтгэл үзүүлж ажиллалаа. Энэ сард багийн иргэдийн нийтийн хурлууд зарлагдаж 5 дугаар сарын 11нд шинэ булаг багийн иргэдийн нийтийн хурал хийж багийн айл өрхүүдийг бүлгийн зохион байгуулалтад оруулж ахлагч нарыг сонгох, малын тоо, толгойн албан татварыг төвлөрүүлэлт, зарцуулалт, багийн иргэдэд өвөлжөө, хаваржааны газар олгох, үхсэн малын сэг, зэм хог хаягдлыг цэвэрлэх, уул овооны тахилга наадмыг зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Газрын харилцааны ажилтны өдөрт зориулсан спортын 4 төрөлт тэмцээнд тус сумын тамгын газрын албан хаагчид Холимог волейбол- алт, Сагсан бөмбөг эрэгтэй төрөлд хүрэл медал авч амжилттай оролцлоо. 5 дугаар сарын 21нд Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан Хөрөнгө оруулалт хөгжлийн чуулганд Сумын засаг дарга 3 мэргэжилтэн 2 аж ахуй нэгжийн хамт оролцсон.

5 дугаар сарын 22-ны өдөр Дархан хаан уулаа тахих арга хэмжээ зохион байгуулсан. Дархан хаан уулын тахилгаар 2 насны 144 тооны морь уралдаж, 28 уралдаанч хүүхэд бүртгэлтэй уралдааны замд гарсан байна. Улсын их хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Хосбаяр, Аймгийн засаг дарга М.Идэрбат нараар ахлуулсан ажлын хэсэг тус суманд ажиллаж цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч ард иргэдтэй уулзлаа.

Аймгийн засаг даргын А/317 тоот захирамжын дагуу хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулж багуудад ажиллах ажлын хэсгийг томилоод тоонд гарах бэлтгэл ажил хийгдэж байна. 5.25нд хагас жилийн малын түүвэр

судалгаанд гарах арга зүйн сургалтад цахимаар сумын орлогч дарга болон холбогдох 6 албан хаагч хамрагдаж мэдээлэл авсан.

Байгаль орчин , Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн чиглэлээр

Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд Цайрт менарал ХХК-2500, Олгой булаг ХХК-нь 1000 мод тарьж нийт 3500 мод тарьсан байна.

Сумын засаг даргын А/68 тоот захирамжаар үхрийн гоц халдварт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх тархлаажуулалт хийгдэж байна. Энэ сарын байдлаар 24000 орчим үхэр вагцинд хамрагдаж сумын хэмжээн нийт үхрийн 50 орчим% нь вагцинд хамрагдаад байна. 3-р багийн иргэн М.Сайнбаярын малын суурьт гоц халдварт хонины цэцэг өвчин оншлогдсон тул сумын засаг даргын А/53 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоож өвчиний шинж тэмдэгтэй бүсэд хөдөлгөөнт постын, устгал, ариутгалын, шуурхай штабын ажлын хэсгүүд ажиллаж байна.

2023 оны 05 дугаар сарын 18, 19-ны өдрийн байгалийн онц аюулт үзэгдэл болох хүчтэй цасан болон шороон шуурганы улмаас өнөөдрийн байдлаар сумын хэмжээнд 31 айл өрх гэр оронгүй болж, 5 багийн 296 малчин мал бүхий өрхийн нийт 39982 толгой хорогдож сумын нийт мал сүргийн 8%-ын эзлэж байна. Сумын хэмжээнд нийт төллөвөл зохих 217484 мянган мал үүнээс 178570 эх болох 82,1% мал төллөсөн. Төлийн хорогдол 2339 болж төл бойжилт 98,7% тай байна Мөн шуурганы үеэр сумын онцгой комиссд хүн алга болсон гэх 6 дуудлага ирж эрлийн 2 групп ажиллаж хүмүүсийг эсэн мэнд олж ар гэрт нь хүлээлгэн өгсөн. Сумын хохирол болон хорогдлын мэдээг аймгийн онцгой комисс болон аймгийн онцгой байдлын газарт өдөр тутам хүргүүлэн ажиллаж байна.

Сумын засаг даргын А/70 тоот захирамжаар хохирлын үнэлгээг тогтоох, сэг зэм устгах, ариутгах ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.

Баянгол багт устгалын 4 хүний бүрэлдэхүүнтэй 1 групп, Ланз багт 6 хүний бүрэлдэхүүнтэй 2 групп гарч 4 уурхайгаас 4 техникийн тусламжтайгаар ажиллаж байна.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

ЭМТөвд төрсөн эх – 1
Нийт төрсөн эх – 24
Нас баралт –11 / хавдар-3, бусад-8/
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч – 229
Ор хоног – 1580
Нийт үзлэг – 2011
Эрэгтэй – 829
Эмэгтэй – 1182
Урьдчилан сэргийлэх үзлэг –378

Идэвхитэй хяналт – 718
Жирэмсний хяналт-21/18/86%
Амбулаторийн үзлэг – 717
Анхан – 322
Давтан – 459
Гэрийн дуудлага – 183
Халдварт өвчлөл – 0
Шинэ-0
Хуучин -0
Түргэн тусламжийн дуудлага – 343
Алсын дуудлага – 160
Осол гэмтлийн дуудлага – 10
Эрт илрүүлэг үзлэг
Хөхний өмөн – 870/339/40%
Умайн хүзүүний өмөн – 220/45/20%
Артерийн даралт ихдэлт – 940/381/40,5%
Чихрийн шижин – 1400/474/34%
Сургалт сурталчилгаа
Тараах материал-7
Цахим хуудас-54 төрлийн мэдээлэл байршуулж 10584 хүний хандалт
Танхимын сургалт -8 удаа 214 хүн хамруулсан

ЭМГ – тай хамтран “Хөдөлмөрийн тухай хууль”, “Соёл, Харилцаа хандлага” сэдвүүдээр ЭМГ-ийн хууль зүйн мэргэлжилтэн Жадамба, хүний нөөц Г. Тамираа нар ЭМТ – ийн 21 ажилчидад сургалт зохион байгуулж хамтран ажиллав.

Энэ жил эрүүл жиндээ аяны хүрээнд “ Өдөрт 1 сүү, 1 тараг сургалтын цэцэрлэгийн багш, сурагчид, эцэг эхчүүдэд сургалт хийж, зөвлөгөө өгөв ”2023.05.04нд Бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдах газрыг цэвэрлэн хамтран ажилласан.

ЭМТ – ийн Ажилчид болон асран хамгаалагчдад хэвтрийн өвчтөний асаргаа болон гэрийн асаргаа сувилгааны сургалтыг Аймгийн “Од сувилгааны газартай” хамтран ажиллаж зохион байгууллаа

Боловсролын чиглэлээр:

Албан байгууллага, багуудын дунд **"Оюун ухааны наадам-2023"** наадмыг сургууль, эцэг, эх, олон нийтийн хамтын үйл ажиллагааг сайжруулах, IQ чадварын ач холбогдлыг сурталчлах таниулах зорилгоор зохион байгууллаа.

Сурагчдын англи хэлний мэдлэг чадварыг хөгжүүлэх зорилгоор 6-р ангийн сурагчдын дунд англи хэлний массын олимпиадыг амжилттай зохион байгууллаа. Энэхүү олимпиадыг 3-р багийн малчин Улсын аварга малчин Батболдын Сүхбаатарын гэр бүл ивээн тэтгэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн Т. Золзаяа, Сүхбаатар аймгийн насан туршийн боловсрол төвийн нийгмийн ажилтан А. Батбаатар нартай хамтран "ТЭГШ БОЛОМЖИЙГ ХАМТДАА" сургалтыг хамтран амжилттай зохион байгууллаа. Уг өдөрлөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний асран хамгаалагч, иргэд хамрагдаа.

Дотуур байранд амьдардаг сурагчдын эцэг эхийн уулзалт өдөрлөгийг 5 дугаар сарын 12 -нд зохион байгууллаа. Байрын багш Г.Оюунцэцэг дотуур байрны танилцуулга болон 2022-2023 оны хичээлийн жилд зохион явуулсан үйл ажиллагаа мөн энэ хичээлийн жилд амжилт гаргасан сурагчдын амжилтыг танилцууллаа. Ирсэн эцэг эхчүүддээ хоолны амталгаа хийсэн. Дотуур байрын үйл ажиллагааны талаар санал асуулга авлаа. Уг өдөрлөгт давхардсан тоогоор 54-н эцэг эх буюу 73,9 хувьтай хамрагдсан.

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын төв 5 дугаар сард:

- Ирсэн бичиг – 3
- Явсан бичиг – 1
 - Хариутай бичиг – 0
 - Хугацаандаа явсан бичиг – 0
 - Хугацаа болоогүй бичиг – 0
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1. Монгол Улсын Соёлын Яамнаас зохион байгуулсан "СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ СУРГАГЧ БАГШ" бэлтгэх сургалтанд Соёлын төвийн дарга Д.Болорцэцэг, номын санч А.Цэцэгмаа нар хамрагдлаа.

1.2. МУСТА дуучин Пүрэв-Ойдовын Ганболдын "ХҮН УУЛ" аялан тоглолтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр танхимаар зохион байгууллаа. Нийт 18 хүн үзэж сонирхсон. Хамрагсад 4.

1.3. Сүхбаатар аймгийн аварга хүлэг шалгаруулах "ЖАВХЛАНТ ШАРГА" Улсын тэргүүний Сүхбаатар суманд 2023 оны 05 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус наадмын нээлтийн үйл ажиллагаанд урлагийн номер бэлтгэн хүргэж, 2 өдрийн турш хөгжим техникээр үйлчилэн, соёл урлагийн үйл ажиллагаагаар хангасан болно. Тус наадмын нээлтийн задгай талбайд нүүдлийн хэлбэрээр нийт 153 хүнд хүргэж ажилласан. Хамрагсад 6.

1.4. Сүхбаатар аймгийн аварга хүлэг шалгаруулах "ЖАВХЛАНТ ШАРГА" наадамд зориулан "Мэргэн Жанжин" сурын холбооноос зохион байгуулсан "Үндэсний сурын харваа"-ны нээлтийн үйл ажиллагааг нүүдлийн хэлбэрээр буюу сурын талбайд

зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагааг нийт 73 хүнд хүргэж, соёл урлагийн үйлчилгээ үзүүлсэн болно. Хамрагсад 6.

1.5. Залуу уран бүтээлч дуучин Батжаргалын Отгонбаярын "БИ ИЙМ Л ХҮН" аялан тоглолтыг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр танхимаар зохион байгуулж нийт 201 хүнд хамруулсан. Хамрагсад 5.

1.6. МУСТА дуучин Я.Гэрэлчулууны "Сайхан цагийн эхлэл Я.Гэрэлчулуун HIT'S" уран бүтээлийн аялан тоглолтыг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр танхимаар зохион байгуулж 54 хүнд хүргэсэн. Хамрагсад 3

1.7. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын унаган охин Уртын дуучин Тунгалагтуяагийн ЦЭНДСҮРЭН-гийн "НАР МАНДДАГ МИНИЙ НУТАГ" уран бүтээлийн тоглолтыг 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдөр танхимаар зохион байгуулж, 110 хүн үзэж сонирхсон. Хамрагсад 4.

1.8. Монгол орны тахилгын шилдэг зан үйлтэй "ДАРХАНХААН" уулын тахилга наадмын нээлтийн үйл ажиллагааг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр нүүдлийн хэлбэрээр буюу "Найрын дэнж"-д зохион байгууллаа. Наадмын хүрээнд 2 насны хурдан морины уралдаан, үндэсний бөхийн барилдаан, үндэсний сурын харваа зохион байгуулагдсан бөгөөд бүтэн өдрийн турш хөгжим техникээр үйлчилэн, соёл урлагийн үйл ажиллагаагаар хангасан болно. Нээлтийн үйл ажиллагаанд 400 хүн хамрагдсан. Хамрагсад 6.

1.9. Монгол орны 6 аймаг 50 суманд хэрэгжиж байгаа "ДДЭШ Соёлын элч" аяныг ДДЭШ компанитай хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд үндэсний соёл урлаг, спорт, оюуны өмчийг дээдлэн, соёл урлагийн салбар хувь нэмрээ оруулах үүднээс "Оюуныг гэрэлтүүлж, соёлыг түгээнэ" уриалга дор 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Тус өдөрлөгийн хүрээнд кино өдөрлөг зохион байгуулсан бөгөөд хүүхэд багачуудад зориулан 2023 оны шинэ бүтээл болох "MUMMIES" хүүхэддэйн кино, бүх насныханд зориулан "ДУУСДАГГҮЙ АМЬДРАЛ" монголын уран сайхны киног тус тус олон нийтэд толилуулж, 81 хүнийг хамрууллаа. Мөн ДДЭШ компаниас Зүүн бүсийн Жишиг Соёлын төвд "Соёлын элч" батламжийг гардуулсан болно.

1.10. Монголын уран сайхны "Нууц тархи" уран сайхны киног танхимаар олон нийтэд толилуулсан. Нийт 87 хүүхэд үзэж сонирхсон.

ХОЁР: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2.1. 2023 оны 05 сарын 18-ны өдөр Сүхбаатар сумын номын сангаас 33 дахь удаагийн "Номын баяр-2023" хүүхэд бүр уншигч аяныг Улсын тэргүүний цэцэрлэг, ЕБС-ийн номын сан, Насан туршийн боловсролын төв, Англи хэлний багш Ө.Алтанчимэг нартай хамтран зохион байгуулав.

1. Номын баярын нээлтийн арга хэмжээнд "Ардын хувьсалыг үндэслэн байгуулагч их жанжин Д.Сүхбаатарын номын булан" тохижуулах ажлыг санаачлан хэрэгжүүлэгч сумын ИТХ-ын төлөөлөгч С.Лхагвадорж хувиасаа санхүүжилт гарган Д.Сүхбаатарын холбогдолтой 30 гаруй ном, фото зураг түүхэн сурвалж баримт бичгийн цуглуулгаар хандив өргөлөө.

2. Ерөнхий Боловсролын сургуулийн номын сангийн өртөө том номын үзэсгэлэн, фазла тоглоом тоглуулан, бийрэн бичгийн дугуйлангийн сурагчид өөрсдийн сурсан зүйлээр танилцуулга хийж сонирхуулав.

3. Улсын тэргүүний цэцэрлэгийн хамт олон номын багц, 30 гаруй төрлийн 3D шинэ номын үзэсгэлэн гаргаж хүүхэд багачуудад чанга уншлага зохион явуулав.

4. Нийтийн номын сангаас цаасан нугалбар, үгийн сүлжээ таах өртөөг ажиллуулан, оролцогч нарын дунд "Чанга шивнээ" хөгжөөнт тэмцээнийг зохион явуулав.

5. Насан туршийн боловсролын төвийн багш Улаанаа даамны тэмцээн, алаг мэлхий өрөх, шагай няслах уламжлалт тэмцээнүүдийг зохион явуулав.

6. Англи хэлний багш Ө.Алтанчимэг "Англи хэлээр хэрхэн ном унших вэ? сэдвээр илтгэл тавьж, дугуйлангийн сурагчдын сэтгэгдлийг яриулж номын тэмдэглэлийг танилцуулав.

2.2. Ардын хувьсгалыг үндэслэгч Д.Сүхбаатарын нэрэмжит номын буланг санаачлагч, ивээн тэтгэгч С.Лхагвадорж Сүхбаатарын холбогдолтой фото зураг, ном хэвлэл 35 ширхэг, бусад баримт бичгийн эх сурвалжаар номын сандаа баяжилт хийсэн.

2.3. Улаанбаатар хотын "Хөгжлийн түүхээ" ТББ тэргүүн Энхцэцэгтэй хамтран ажиллах санал солилцож эхний ээлжинд 20 ширхэг англи ном, 30 ширхэг хүүхдийн ном хандивлан, номын сандаа баяжилт хийсэн. Номын баяр нэгдсэн арга хэмжээнд нийт 88 хүн хамрагдсан.

2.4. Дэлхийн номын өдөрт зориулан "Үлгэрийн баатрууд амилсан нь" дүрийн тоглолтыг Улсын тэргүүний цэцэрлэгийн 6 бүлгийн 120 хүүхдийн дунд зохион явуулав. Энэхүү тэмцээнийг 3-р багийн сумын сайн малчин Б.Амартайваны гэр бүл 300,000 төгрөгөөр ивээн тэтгэж оролцов. Тэмцээний 1-р байр Э.Нямгэрэл багштай "Бамбарууш" бүлэг, 2-р байр Б.Гэрэлтуяа багштай "Янзага" бүлэг, 3-р байранд Д.Болормаа багштай "Хэрэмхэн" бүлэг тус бүр шалгарсан. 67 хүн үзэж сонирхсон.

2.5. Д.Цэвээндулам багштай 5а ангийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран “ХАЛУУН СЭТГЭЛ-ХАЙРЫН ҮР” сайн үйлсийн аян өрнүүлж байгалийн болон гэнэтийн давтагдашгүй хүчин зүйлд өртсөн 5а ангийн суралцагч Л.Түвшинжаргалын гэр бүлд бараа материал, ахуйн хэрэглээний бараа 407,000 төгрөгийн хандив цуглуулан хүлээлгэж өглөө.

5 -р сард шинэ уншигч-2, ирэгсэд 85 гэрээр олгосон ном 9 танхимаар олгосон ном 98 нийт 117 ном олгосон. Шинэ номын үзэсгэлэн-1 удаа 70 ширхэг номоор 68 хүүхдэд үйлчлэв.

ГУРАВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

3.1. Монголын Арьсан урлагийг хөгжүүлэх холбооны тэргүүн МУСТА Ч.Баярсайханы уран бүтээлийн "МОНГОЛ ӨВ СОЁЛ" үзэсгэлэн 2023 оны 05 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд Соёлын төвийн Соёлын өвийн танхимад зохион байгуулагдлаа. Тус үзэсгэлэнг нийт 60 гаруй хүн үзэж сонирхон Монгол өв соёлоо бахархан, хүндэлж мэлмийгээ баясгалан 80 хувийн худалдан авалтыг хийж, уран бүтээлчдийг дэмжсэн болно.

3.2. Сүхбаатар сумын орон нутаг судлах музейг сумын сургуулийн 1979 оны төгсөлтийн 30 хүнд тайлбар хийж үзүүлэн музейн үйлчилгээ хүргэсэн.

3.3. Сүхбаатар аймгийн Цагдаагийн хэлтсийн албан хаагчид Орон нутаг судлах музейд зочилсон. Нийт 35 хүнд музейн үйлчилгээ үзүүлсэн.

3.4. Ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн 50 сурагчид музейн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэж, тайлбарлан үзүүлсэн.

3.5. Даалин урлал, сүлжмэл, нэхмэл гутал, ээмэг зүүлт өвийн төрөлд Соёлын өвлөн уламжлагчаар Лхагвасүрэн овогтой Намхайг бүртгэн, бүртгэл мэдээллийн сан үүсгэсэн. Л.Намхай нь Д.Сүхбаатарын нэрэмжит 1-р 10-н жилд сурч байхдаа Хөдөлмөрийн багш Г.Нарантуяагаар, О.Буд нараар анх даалин урлал, сүлжмэл, нэхмэл урлалыг зааж сурсан. 2011 онд Улаанбаатар хотын даалин урлалын багш О.Удвал гэдэг хүнээр нарийвчлан заалгаж сурсан. 2023 оны 4-р сараас даалин урлал, гар урлалын анхны сургалтыг танхимаар зааж байна. Энэхүү сургалтанд 8 хүн хамрагдаж байна

ДӨРӨВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

4.1. Дасгал хөдөлгөөнөөр эрүүлжих, хөдөлгөөний дутагдлаас ангижрах, бүжгийн урлагаар дамжуулан гоо зүйн мэдрэмж олгох зорилготой "ЭМГҮЙГЭЭР ЭРҮҮЛЖЬЕ" нийтийн цэнгээнт бүжгийн сургалт 10 хоногийн турш өдөрт 3 удаа хичээллэж, амжилттай өндөрлөсөн. Бүжгийн сургалтыг удирдан явуулсан Монголын бүжгийн

спортын холбооны бүжгийн багш Ж.Энхбаатар, Д.Болортуяа нартаа гүн талархал илэрхийлье. Тус сургалт нь 10 хоног үргэлжлэх бөгөөд Хүмүүн төрөлхтөн, Задгай цагаан, Ёохор, Румба, Өндөр дэлгүүр, Вальс Бостон, Краковъяк, Венгерка, Падеспани, Түстеп, Фокстрот зэрэг бүжгийг зааж сургасан. Сургалтанд нийтдээ 50 хүн хамрагдсан болно.

4.2. Дуу хөгжмийн багш Л.Батжаргал ЕБС-ийн сурагчдад ятга хөгжмийн дугуйланг 5 дугаар сард 8 удаа хичээллүүлэлээ. Ятга хөгжмийн дугуйланд нийт 12 хүүхэд хамрагдсан.

4.3. Аймгийн хүүхдийн урлагийн “Шувуухай” наадамд Улсын тэргүүний цэцэрлэгийн хүүхэд багачуудын бэлтгэлийг хангуулж ажиллаа. Бэлтгэлийг 7 хоногийн турш өдөрт 2 удаа соёлын төвийн байранд зохион байгуулсан. Хамрагсад 20.

4.4. Олон нийтэд зориулсан нийтийн цэнгээнт бүжгийг нийт 5 удаа зохион байгуулж танхимаар 246 хүнийг хамруулсан.

ТАВ: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1. Малчид, ард иргэдэд зориулан “Бэлчээрийн талхдалт эко оряны төслийн уулзалт”-ыг танхимаар зохион байгуулж 13 хүнийг хамруулсан.

5.2. Сүхбаатар сумын Соёлын төвд 18 жил номын санчаар ажилласан ахмад номын санч Марайсан овогтой Бадамцэцэгийг Монгол улсын Засгийн газрын шагнал “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнаж, шагналыг Дарханхаан уулын тахилгын нээлтийн үйл ажиллагааны үеэр гардуулсан.

5.3. УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал, аймгийн Засаг дарга М.Идэрбат нар Сүхбаатар сумын иргэдтэй уулзсан. Энэхүү уулзалтыг Соёлын төвийн танхимд зохион байгуулсан. Хамрагсад 87.

5.4. 2023 оны 05 дугаар сарын 19-20 өдрүүдэд байгалийн онц ноцтой гамшиг болж, цасан болон шороон шуурга шуурсан. Үүний улмаас Соёлын төвийн байрны урд хэсгийн пасад хэсэгчилэн хууларч, мод ургамал хугарч унасан. Байгууллагын албан хаагчид гамшгийн дараах их цэвэрлэгээг хийж, ойр орчимд үүссэн их хэмжээний хогийг цэвэрлэсэн.

5.5. Байгууллагын дотоод хурлыг 2 удаа зохион байгуулж, цагийн үеийн асуудал болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцсэн.

5.6. Хүүхэд хөгжүүлэх танхимыг тохижуулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Тус танхимд хүүхдэд зориулсан номын шүүгээ тавиур 3 ширхэгийг өөрсдөө хийж байрлуулсан.

5.7. Соёлын төвийн хамт олон сумын үйлвэрчний эвлэлийн даргатай уулзаж, хамтран ажил талаар санал бодлоо солилцов. Соёлын төвийн үйлдвэрчний эвлэлийн хороо байгуулсан.

5.8. Соёлын төвийн бүх ажилчид үйлчлэгч Г.Оюунномингийн хүү О.Түвшинбаярыг хагалгаанд дэмжлэг үзүүлэн 120,000 төг хандив өгсөн.

5.9. Хатагин судлалын эрдэмтэд эрдэм шинжилгээний уулзалтыг Соёлын төвд зохион байгуулсан. Тус уулзалтанд нийт 36 хүн хамрагдсан.

5.10. Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газраас Сүхбаатар суманд гамшгийн эрсдлийн иж бүрэн сургалт хийж, жагссан. Үүнд Соёлын төвийн 3 албан хаагч хамрагдсан.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Зүүн бүсийн жишиг соёлын төв нь 2023 оны тавдугаар сарын байдлаар **29** үйл ажиллагаа зохион байгуулж, танхимын болон явуулын үйлчилгээгээр танхимаар **1680** үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээ, арга хэмжээг хүргэн ажилласан. Хамрагсадын тоо **364**

БОЛОВСРУУЛСАН:

МЭДЭЭ ГАРГАСАН :

Дотоод ажилтан, Хууль, эрх зүйн мэргэжилтэн

/С.Ариунзаяа/

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/